

**Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид хуралдлаа**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 5-н сард 2 удаа хуралдан 13-н асуудлыг авч хэлэлцлээ. **2015 оны 5-р сарын 15-ны** өдөр дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.



1. Бурхан багийн сэрэг дүр, хүүхэд залуучуудын паркийн байгууламжийн асуудлыг сайжруулах тухай

2. Худалдан авах ажиллагааны албаны 2013, 2014 оны ажлын тайлан, 2015 оны зорилт мэдээлэл
3. Шинэ дулааны станцын үйл ажиллагааны мэдээлэл, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болох тухай
4. ОНӨ актлах, худалдах тухай
5. Маршал Ю.Цэдэнбалыг цагаатгах ажлыг дэмжүүлэх тухай
6. Шагналд тодорхойлох тухай

2015 оны 5-р сарын 25-ны өдөр дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

1. Увс нуурын дэргэдэх аялал жуулчлалын гэр баазыг менежментийн үр дүнг харгалзан хувьчлах гэрээний төслийг батлах тухай
2. ИТХ-ын Хяналтын журам батлах тухай
3. Сумдын хилийн цэсийн эргэлтийн цэгийг хэлэлцсэн тухай
4. Хуулийн хэрэгжилтийг хангах тухай
5. ОНӨ худалдах тухай
- 6.
7. Мэдээлэл технологи, шуудан харилцаа холбооны газрын 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай
8. Шагналд тодорхойлох тухай

"Төвлөрсөн захуудын дэд бүтцийг шийдэх замаар орчин нөхцлийг сайжруулж, эрүүл ахуйн стандартыг хангах нь" сэдэвт хэлэлцүүлэг боллоо

Хэлэлцүүлгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын алба, Мэргэжлийн хяналтын газар, Иргэний танхимтай хамтран



"Төвлөрсөн захуудын дэд бүтцийг шийдэх замаар орчин нөхцөлийг сайжруулах, эрүүл ахуйн стандартыг хангах нь" сэдвээр 2015.05.04-ний өдрийн 09:00 цагт "Иргэдийн оролцоо" танхимд зохион байгуулав. Хэлэлцүүлэгт

"Улаангом менежмент" захын төлөөлөл, тус захад үйл ажиллагаа явуулдаг худалдаа эрхлэгчид зэрэг 96 хүн оролцов. Хэлэлцүүлэгт оролцсон иргэн, аж ахуйн нэгжийн саналыг хэлэлцсэний дүнд дараах шийдэлд хүрэв.

1. Хөгжлийн бодлогын хэлтэс хариуцан мэргэжлийн байгууллагуудын оролцуулсан ажлын хэсэг гаргаж, шугам сүлжээнд холбогдох трассыг 5-р сарын 11-ний дотор гаргаж өгөх.
2. Шугамын холболтоо иргэн, аж ахуйн нэгжүүд Улаангом менежмент компанийн тохижилтыг ажил эхлэхээс өмнө хийж дуусгах.
3. Захад баригдах нийтийн бие засах газрыг шийдэх өгөх.
4. Улаангом менежмент компани хогны асуудлыг шийдэх. Хэлэлцүүлгийн үеэр гарсан өдөр бүр хог ачих гэрээт ажидчинтай болох асуудлыг судалж шийдвэрлэх.
5. Улаангом менежмент компани тохижилтын ажил хийхдээ мэргэжлийн байгууллагын заавар зөвлөгөө авах, эрсдлийг тооцох.

Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох "Өөрчлөлтийн өөрөөсөө эхлээ" хөдөлгөөн, "Миний гэрээс манай аймгийн хөгжил эхэлнэ" аяны танилцуулга, мэдээлэл хийх иргэд олон нийтийн уулзалт боллоо

Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох "ӨӨРЧЛӨЛТИЙН ӨӨРӨӨСӨӨ ЭХЛЭЭ" хөдөлгөөн, "МИНИЙ ГЭРЭЭС МАНАЙ АЙМГИЙН ХӨГЖИЛ ЭХЭЛНЭ" аяны танилцуулга, мэдээлэл хийх иргэд олон нийтийн хэлэлцүүлэг уулзалт 2015 оны 05 сарын 20-ны өдөр "Ойрад" ХДТ-т боллоо. Хэлэлцүүлэгт Аймгийн ИТХ-ын дарга



Ч.Чимэд, Улаангом сумын Байгаль орчны улсын байцаагч С.Буяндалай, Улаангом сумын орлогч дарга Б.Гомбосүрэн, Элемент ХХК-ны захирал Баярсайхан ЗДТГ-ын дарга Г.Болор-Эрдэнэ, Улаангом сумын ИТХ-ын дарга Жавхлантөгс нар тус тус мэдээлэл хийж иргэдэд танилцууллаа. Уулзалтад Улаангом сумын 9-н багаас нийт 150 гаруй ард иргэд хүрэлцэн ирж санал бодлоо солилцов. Хэлэлцүүлэгт оролцсон иргэд Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар хогны хураамжаа сар бүр төлж Цэвэр цэмцгэр хөггүй орчныг бүрдүүлэхэд санал нэгдэж цаашид энэ арга хэмжээг орчин тойрондоо сурталчлахаар боллоо.

Баруун бүсийн ИТХ-ын нарийн бичгийн дарга болон ЗДТГ-ын дарга нарыг чадавхижуулах сургалт боллоо

Конрад-Аденауэр сангийн санхүүжилтээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газраас хамтран зохион байгуулж буй "Нутгийн удирдлагын манлайллыг хангах нь" сэдэвт сургалт, хэлэлцүүлэг 2015 оны 05 дугаар сарын 25-26-ны өдөр Ховд аймгийн Ховд хотноо амжилттай зохион байгуулагдлаа. Сургалтад Ховд, Увс, Баян-Өлгий аймаг, сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нийт 120 орчим хүн оролцож байна.

Сургалтаар "Төрийн албан хаагчийн харилцааны сэтгэл зүй", "Ухаалаг харилцаа-амжилтын үндэс", "Орон нутгийн засаглалын менежментийг сайжруулах асуудал", "Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт, шинжилгээ-үнэлгээний асуудал" зэрэг сэдвүүдээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын референтүүд, аймаг, сумдын ИТХ-ын



Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга нар харилцан туршлага солилцлоо.

Энэхүү сургалтын үр дүнд нутгийн өөрөө удирдах болон захиргааны мэргэшсэн албаны удирдах ажилтнуудын албан ажилд чухал хэрэгцээтэй мэдлэг, мэдээлэл өгч, хөрш зэргэлдээ аймаг, сумд албан ажлын туршлага солилцож байгаагаараа ач холбогдолтой сургалт боллоо.



FOOD SAFETY



2015 оны 05-р сар

Алдарт эхийн одон гардуулгаа

Эх үрсийн баярыг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 05-р сарын 27-ны өдрийн 79-тоот зарлигаар олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхчүүдэд “Алдарт эх”-ийн нэг, хоёрдугаар зэргийн одон гардуулахаар боллоо. Увс аймгаас Алдарт эхийн 1-р одонгоор 39, Алдарт эхийн 2-р одонгоор 291, нийт 330-н Эх алдарт эхийн одонгоор энгэрээ мялааж байна.



Улаангом сумаас 1-р одонгоор 7, 2-р одонгоор 85 нийт 92 эх шагнагдсан бөгөөд Алдарт эхчүүдийн одонг Эх үрсийн баярын өмнө “Галдан бошигт” хааны хүндэтгэлийн өргөөнд ёслол төгөлдөр гардуулж өглөө.

Ёслолд Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Х.Төртогтох, АЗДТГ-ын НХХ-ийн дарга Б.Ядамсүрэн, Улаангом сумын ИТХ-ын дарга Б.Жавхлантөгс, Улаангом сумын Засаг дарга О.Ганхуяг нар оролцож эхчүүдэд Алдарт эхийн одон тэмдгийг гардуулан өглөө.

Увс аймагт есөн метр өндөр номон суварга сүндэрлэлээ

“Шинэ тэмүүлэл” залуучуудын клубээс санаачлан Увс аймгийн түүхт 90 жилийн ойд зориулж Ерөнхий боловсролын 30 сургуулийн номын сангийн фондыг шинэ, шинэлэг номоор баяжуулах зорилготой цахим орчинд давлагаалуулсан “Book challenge” аян амжилттай явагдаж 37 мянга орчим ном сургуулиудын номын санд очиход бэлэн боллоо.

Увсаас эхэлж, дэлхий даяар давлагаалсан тус аяны хаалтын арга хэмжээ Увс аймгийн



Ю.Цэдэнбалын талбайд ёслол төгөлдөр боллоо. Номын баярын үеэр 19 сумын 30 сургуулийн захирал, номын санч, сурагчдын төлөөлөл оролцсон бөгөөд дунд, ахлах сургууль тус бүр 1000 номын, бага сургуулиудад тус бүр 100 ширхэг ном хандивлах БАТЛАМЖ-ийг гардууллаа

Зүүнхангай сум:

Сумын хөгжлийн алсын хараа “Уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, орон нутгийн нөөцөд түшиглэсэн жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ, туслах аж ахуй, дэд бүтэц хөгжсөн хүний хөгжлийн чадавхтай зүүн бүсийн эдийн засагт нөлөө бүхий хөгжиж буй сум болно” хэмээн сумын хөгжлийн хөтөлбөрт тусгасан байдаг ч учир дутагдалтай байна гэсэн дүгнэлтийг Сумын ИТХ – ын Тэргүүлэгчид хийж сум орон нутгаа хөгжүүлэх гол гарц нь сумын бүх иргэд оюуны чадавхаа байнга дээшлүүлж мэдлэгтэй болж иргэдийн оролцоог одоогийн байгаа хэмжээнээс эхний ээлжинд нэг дахин, цаашдаа иргэдээ 100% хамруулдаг болсноор сумын хөгжлийн 1 – р гарц тодорхойлогдоно гэж үзсэнээр сумын бүх байгууллага, багуудын оролцоотойгоор боловсролыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах аянд оны эхнээс шамдан ажиллаж 4 – р сарын ИТХ – ын хуралдаанаар хэлэлцэн баталсан юм. Ийнхүү Сумын бүх нийтийн боловсролыг 2015 – 2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр – тэй боллоо.

Ховд сум:

“Миний гэрээс манай сумын хөгжил эхэлнэ” аяны удирдамжийг баталж уг аяны хүрээнд ИТХ –ын тэргүүлэгчид ажлын хэсэгтэй хамтран гэр хороололд 1 өдөр ажиллаж зөвшөөрөлгүй газар эзэмшиж байгаа иргэдэд мэдэгдэл өгөх, хашаа хороог зосдож янзлах, тэгшлүүлэх арга хэмжээг авлаа. Хүүхдийн баяраар “Алдарт эх” 1.2-р зэргийн одонгоор шагнагдсан 8 эхийн одонг гардуулан өглөө. Мөн цэвэр орчин аяны хүрээнд хийгдсэн ажлын тайланг сонсож үнэлэлт дүгнэлт өгөв.

Хяргас сум:

Ахлах сургуулийн 90 жилийн ойн арга хэмжээний хүрээнд ахмад багш Д.Батаагийн нэрэмжит Математикийн олимпиадыг зүүн 9 сумын сурагчдын дунд амжилттай зохион байгуулж явууллаа. Уг арга хэмжээнд 25 багш, 6-11 дүгээр ангийн 69 сурагч оролцож 24 медалийн төлөө оюун ухаанаа уралдуулж Тэргүүн байранд Зүүнговь сум 8 медаль, Хяргас сум 8 медаль, Тэс сум 2 медаль авч эхний байруудыг эзлэв. Мөн энэ үеэр элсэлтийн ерөнхий шалгалтын шалгалтын их сунгаанд 46 хүүхэд оролцоноос 79% гүйцэтгэлээр Өндөрхангай, 73% Зүүнговь, Хяргас 73% сумын сурагчид амжилттай оролцлоо. Энэхүү арга хэмжээнд УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар, Аймгийн МАН-ын даргын үүрэг гүйцэтгэгч Ч.Насанбат нар оролцов.

Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг Ө.Бадрахын гудамж, ЗДТГ-ын байр 210 тоот

Утас : 70453627

Факс : 70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

<http://uvs.khural.mn/>

Facebook:

www.facebook.com/groups/uvs.ith